



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 6/588

Улаанбаатар хот


Х.Жайлаубайд буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь гаалийн газарт галчаар ажиллаж байгаад тус гаалийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарч, ажлаас чөлөөлөгдсөн Хавданы Жайлаубайд төрийн алба хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 14806000 /арван дөрвөн сая найман зуун зургаан мянган/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/ -т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 1781